

Завхан аймгийн хүн ам зүйн орчны судалгаа

С. Бурмаа

МУИС-ийн Завхан аймаг дахь Эдийн Засгийн Салбар Сургуулийн багш, магистр

Д.Нар-Од

МУИС-ийн Завхан аймаг дахь Эдийн Засгийн Салбар Сургуулийн багш, магистр

Хүн ам зүйн асуудал гэдэг нь аливаа улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудалд чухал байр суурь эзэлдэг. Энэхүү судалгааны ажлаар Завхан аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийг цогц байдлаар нэгтгэн харуулахыг зорьсон бөгөөд аймгийн хөгжлийн төлөвлөлтийн анхдагч материал болгон ашиглахад оршсон болно. Судалгаанд ашигласан хүн ам зүйн үзүүлэлтүүдийг аймгийн бүх сумдаар харьцуулан судлав. Судалагааны үр дүнгээс харахад Завхан аймгийн хувьд хүн амын асуудлуудад эерэг болон сөрөг хандлагууд ажиглагдаж байгаа бөгөөд шийдвэр гаргагчид цаашид сөрөг хандлагуудад анхаарахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, хөрөнгийг хуваарилах нь зүй ёсны асуудал болж байна.

Бүс нутаг болон хөдөө орон нутгийн хөгжүүлэхэд хүн ам зүйн асуудалд анхаарлаа хандуулж энэ чиглэлийн судалгааг дэс дараатай үе шаттайгаар илүү нарийвчлан судалж, нийгэм эдийн засгийн бусад асуудлуудтай холбон авч үзэх шаардлагатай байна. .

Түмхүүр үгс:

Хүн амын нас хүйсийн бүтэц, хэтийн төлөв, суурьшил, төрөлт, нас баралт, ажил эрхлэлт, ажилгүйдэл

Энэхүү судалгааг Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын дэмжлэгтэйгээр 2007 онд хийсэн болно. Судалгаагаар сумуудын нийт хүн ам, тэдгээрийн өсөлт, өөрчлөлт, хэтийн төлөв, насны бүтэц, хүйс, төрөлт, нас баралт, суурьшлын асуудлуудыг судалсан болно.

1. Завхан аймгийн нийт хүн амын өсөлт өөрчлөлт, хэтийн төлөв

Завхан аймаг нь 1997 онд 102.2 мянган хүн амтай байсан бол 2006 онд 79.0 болж эрс буурчээ. Энэ нь хүн амын төрөлт багассан, шилжилт хөдөлгөөн ихэссэн, сум орон нутагт ажлын байр бага, зуданд амьжиргааны эх үүсвэр болсон малаа алдаж, өөр аймаг, төв бүс рүү шилжих хөдөлгөөнд оролцсон зэрэг олон шалтгаантай холбоотой юм.

2006 оны байдлаар Завхан аймгийн нийт хүн амын 20.3 хувийг Улиастай сум, 11.3 хувийг

Тосонцэнгэл сум, 7.6 хувийг Их-Уул сум эзэлж байна. Сумын нийт хүн амын тоогоор ангилж үзвэл, 1000-2000 хүн амтай 8 сум байгаа ба энэ нь аймгийн нийт хүн амын 16.4 хувийг, 2000-3000 хүн амтай 9 сум байгаа нь аймгийн нийт хүн амын 26.5 хувийг, 3000-4000 хүн амтай 4 сум байгаа нь аймгийн нийт хүн амын 17.3 хувийг, 6000 дээш хүн амтай 3 сум байгаа нь аймгийн нийт хүн амын 39.5 хувийг тус тус эзэлж байна. Эндээс цөөн хүн амтай сумын тоо харьцангуй олон байгаа нь харагдаж байгаа бөгөөд энэ нь сум орон нутгийн зах зээлийн багтаамж бага, үйлдвэрлэл хөгжүүлэх боломж сул, сум орон нутгийг хөгжүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж болох талтай юм.

Монгол Улсын болон Баруун бүсийн нийт хүн амд Завхан аймгийн хүн амын эзлэх хувийг 2003-2006 оны байдлаар Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Улсын болон баруун бүсийн хүн амд Завхан аймгийн нийт хүн амын эзлэх хувь, 2003-2006 он								
Хүн амын тоо	2003		2004		2005		2006	
	Нийт хүн ам /мян/	Завхан аймгийн хүн амын эзлэх %	Нийт хүн ам /мян/	Завхан аймгийн хүн амын эзлэх %	Нийт хүн ам /мян/	Завхан аймгийн хүн амын эзлэх %	Нийт хүн ам /мян/	Завхан аймгийн хүн амын эзлэх %
Улсын	2504.0	3.3	2533.1	3.2	2562.4	3.1	2594.8	3
Баруун бүсийн	414.5	20	411.6	19.6	409.0	19.5	410.0	19.7

Эх үүсвэр: УСГ, 2006. Монгол улсын статистикийн өмхэтгэл 2006, Улаанбаатар


Өгөгдсөн мэдээллээс харахад Завхан хүн ам буурах хандлагатай байгаа бөгөөд хүн амын өсөлтийн хурд -0.005 болж хасах тэмдэгтэй гарч байна. Энэ нь Завхан хүн ам жилд дунджаар 0.005 хувиар буурч байна гэсэн үг юм. Хүн амын өсөлтийн хурдыг сум бүрээр тооцож үзэхэд Эрдэнэхайрхан, Баянхайрхан сумдад өсөлтийн хурд хамгийн удаан байгаа ба Отгон сумаас бусад бүх сумдын хүн ам буурах тооцоо гарч байна.

дунджаар 0.8-1 дахин буурах тооцоо гарч байна. Ийнхүү аймаг, орон нутгийн хүн амын ирээдүйн тоо хэмжээ жилээс жилд багасвал, эргээд нийгэм эдийн засгийн өсөлт ялангуяа, сум орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх, сум орон нутгийн хөгжил, хот суурин газрын төвлөрлийг сааруулах зэрэгт сөрөг нөлөө үзүүлэх нь лавтай юм. Иймд Завхан аймаг нь хүн ам зүйн асуудалд онцгой анхаарах нь чухал гэдгийг тод харж болохоор байна.

Хүнамын жилийн дундаж өсөлтийн дооогийн хандлага цаашид үргэлжилнэ гэж төсөөлөөд Завхан аймгийн бүх сумуудын хүн амын хэтийн төлвийг хэтийн тооцооны арифметик загварыг ашиглан 2007-2015 он хүртэлх хүн амын хэтийн хандлагыг тооцоход бүх сумдын хүн амын тоо жилээс жилд буурах хандлагатай байна. Тухайлбал, 2015 он гэхэд аймгийн нийт хүн амын тоо 2006 оныхоос

2. Завхан аймгийн хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын насны бүтцийг судалснаар нөхөн үржихүйн цаашдын хандлага, хөдөлмөрийн нөөц, ажиллах хүчний түвшинг харах ач холбогдолтой юм. 2006 оны байдлаар Завхан аймгийн хүн амын нас, хүйсийн суваргыг доор дүрслэж үзүүлэв.



Эх үүсвэр: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчны судалгаа 2007 он

Бүх сумдын хувьд сумын нийт хүн амын 38-45 хувийг 0-19 насныхан эзэлж байгаа ба 20-34 насныхны хувийн жин (25-30%) ч өндөр байна. Харин 35-54 насныхан 18-24 хувийг, 55-с дээш насныхан 10 хүрэхгүй хувийг тус тус эзэлж байна. Ийнхүү сумдын хүн амд залуу болон идэр насны хүн ам өндөр хувьтай байгаа нь Завхан аймгийн хөдөлмөрийн нөөцийн өнөөгийн боломжит байдлыг илтгэн харуулж байна.

Хүүхэд, насанд хүрээгүй хүн ам буюу 0-19 насныхан хамгийн их өндөр хувьтай сум нь Ургамал (45.9%) харин хамгийн бага хувьтай сум нь Эрдэнэхайрхан (37.3%) байна.

20-34 насныхан хамгийн өндөр хувьтай байгаа сум нь Эрдэнэхайрхан (32.1%), хамгийн бага байгаа сум нь Дөрвөлжин (23.5%) байна. Харин 35-54 насныхан Завханмандал суманд (25.9%) хамгийн өндөр хувийг, Их-Уул суманд (18.3%) хамгийн бага хувийг эзэлж байна.

Хүн амын насны бүтцийн судалгааны үед хүн амын зүйн ачааллыг тооцох нь чухал бөгөөд тухайн улсын хөдөлмөрийн нөөцийн хангамжийг тодорхойлдог үзүүлэлт юм. Хүн ам зүйн ачааллыг сум бүрээр Хүснэгт 2-д харууллаа.

Хүснэгт 2. Завхан аймгийн хүн ам зүйн ачаалал /2006 он байдлаар/				
№	Сумын нэр	Ерөнхий ачаалал	Хүүхэд насны ачаалал	Өндөр настны ачаалал
1	Алдархаан	50.89	42.93	0.08
2	Асгат	52.01	44.52	0.07
3	Баянтэс	55.70	51.08	0.05
4	Баянхайрхан	53.28	46.88	0.06
5	Дөрвөлжин	55.22	48.76	0.06
6	Завханмандал	51.48	44.52	0.07
7	Идэр	57.17	49.62	0.08
8	Их-Уул	56.96	51.07	0.06
9	Нөмрөг	57.24	50.21	0.07
10	Отгон	58.44	50.9	0.08
11	Сантмаргац	62.46	56.66	0.06
12	Сонгино	45.91	40.2	0.06
13	Тосонцэнгэл	49.06	41.89	0.07
14	Түдэвтэй	54.11	47.12	0.07
15	Тэс	55.01	50.8	0.07
16	Тэлмэн	56.26	49.55	0.07
17	Ургамал	61.74	55.64	0.06
18	Цагаанхайрхан	53.42	44.68	0.09
19	Цагаанчулуут	62.41	50.81	0.12
20	Цэцэн-Уул	59.81	53.14	0.07
21	Шилүүстэй	52.7	46.8	0.06
22	Эрдэнэхайрхан	55.22	48.86	0.06
23	Яруу	50.45	44.35	0.06
24	Улиастай	46.04	40.01	0.06
	Завхан аймаг	55.3	50.1	0.06

Эх үүсвэр: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчны судалгаа 2007 он

Дээрх хүснэгтээс харахад хөдөлмөрийн насны 100 хүнд 45-62 тэжээлгэгч ногдож байгаа нь харагдаж байна. Хүн ам зүйн ерөнхий ачаалал ихтэй сум бол Сантмаргац (62), Цагаанчулуут (62) байхад хамгийн бага ачаалалтай сум нь Сонгино (46), Улиастай (46)

байна. Хүүхэд настны ачаалал Сантмаргац суманд (57) хамгийн өндөр харин Улиастай суманд (40) хамгийн бага байна. Өндөр настны ачаалал ихтэй сум Цагаанчулуут (0.12), хамгийн бага ачаалалтай сум Баянтэс (0.05) байна.

Хүн ам зүйн чухал үзүүлэлтийн нэг нь хүн амын хүйсийн харьцаа юм. Монгол улсын хувьд хүйсийн харьцаа тогтвортой байдаг улс орны тоонд ордог бөгөөд энэ нь хүйсийн харьцаа оновчтой байна гэсэн үг юм. Завхан аймгийн нийт хүн амын 49 хувийг эрэгтэйчүүд, 51 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа улсын дундажтай ойролцоо байна. Гэхдээ Идэр, Их-Уул, Нөмрөг, Яруу сумаас бусад сумдын эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдээсээ өндөр байна. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс олон байгаа сумдыг дурьдвал, Тэлмэн (57.9%), Завхан мандал (57.2%), эсрэгээр эрэгтэйчүүдийн хувийн жин эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа сумд нь Нөмрөг (51%), Их-Уул (50.9%), Идэр (50.5%) байна.

3. Завхан аймгийн хүн амын суурьшилт, төрөлт, нас баралтын түвшин

Хүн амын суурьшлыг сумын төв, хөдөө гэсэн ангиллаар авч үзэхэд нийт сумын хүн амын дийлэнх нь буюу 50-иас дээш хувь нь хөдөө амьдарч байна. Энэ нь сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж байгаа, нөгөө талаар мал болон түүнээс гарах түүхий эдийн үнэ ханш өссөн, сумын төвд ажлын байр хомс байгаа зэрэгтэй холбоотой юм.

Алдархаан, Тосонцэнгэл, Түдэвтэй сумдын сумын төвд амьдардаг хүн амын тоо хөдөө амьдардаг хүн амаас харьцангуй илүү байна. Харин Тэлмэн сумын хөдөө, сумын төвд амьдардаг хүний тоо бараг адилхан байна.

Улс орны нийгэм, эдийн байдал, хүн амын хүчин зүйлээс шалтгаалан өсөж, буурч байдаг хүн ам зүйн нэг үзэгдэл бол хүн амын төрөлт юм. Завхан аймгийн төрөлтийн түвшин өөрчлөлтийг Хүснэгт 3-д 2004-2006 оноор харууллаа.

Хүснэгт 3. Завхан аймгийн сумдын хүн амын төрөлтийн түвшин (1000 хүн амд ногдох), 2004-2006 он							
№	Сумуудын нэр	Төрсөн хүүхэд			Төрөлтийн ерөнхий коэф		
		2004	2005	2006	2004	2005	2006
1	Алдархаан	51	75	61	13	20	17
2	Асгат	25	17	26	22	15	23
3	Баянтэс	67	86	60	22	28	20
4	Баянхайрхан	47	47	25	24	24	12
5	Дөрвөлжин	47	48	54	20	21	24
6	Завханмандал	30	20	22	23	15	17
7	Идэр	41	42	55	15	15	20
8	Их-Уул	122	133	154	19	21	26
9	Нөмрөг	24	30	39	13	16	21
10	Отгон	101	77	86	29	22	24
11	Сантмаргац	41	43	55	19	20	26
12	Сонгино	38	28	32	20	15	16
13	Тосонцэнгэл	132	144	177	15	16	19
14	Түдэвтэй	31	30	22	15	15	11
15	Тэс	69	51	73	21	16	21
16	Тэлмэн	52	51	49	18	18	18
17	Ургамал	30	31	35	16	17	20
18	Цагаанхайрхан	28	37	27	15	20	15
19	Цагаанчулуут	21	25	45	14	17	30
20	Цэцэн-Уул	35	38	54	17	18	25
21	Шилүүстэй	52	38	50	21	16	20
22	Эрдэнэхайрхан	24	17	33	13	10	19
23	Яруу	36	33	60	13	13	24
24	Улиастай	239	304	314	15	19	20
	Завхан аймаг	1383	1445	1608	18	18	20

Эх үүсвэр: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчны судалгаа 2007 он

Завхан аймгийн хэмжээгээр төрөлт сүүлийн 3 жилд 0.8 дахин өссөн байгаа ба цаашдаа төрөлт нэмэгдэх хандлагатай байна. 1000 хүн тутамд 18-20 амьд төрөлт ногдож байна. Хэдийгээр төрөлт нэмэгдсэн үзүүлэлттэй харагдаж буй ч дорвитой өсөлт бий болохгүй байна.

Цагаанчулуут суманд төрөлтийн ерөнхий түвшин хамгийн өндөр (1000 хүн тутамд 30

амьд төрөлт), Түдэвтэй суманд (1000 хүн тутамд 11 амьд төрөлт) хамгийн бага байна.

Нас баралтын түвшин бол хүн ам зүйн асуудлын салшгүй нэг хэсэг юм. Нас баралтын түвшин аливаа улсын эрүүл мэндийн салбарын хөгжил ямар байгааг илтгэх чухал үзүүлэлт юм. Завхан аймгийн хүн амын нас баралтын түвшинг сумдаар Хүснэгт 4-д харуулав.

Хүснэгт 4. Завхан аймгийн сумдын хүн амын нас баралтын түвшин (1000 хүн амд ногдох), 2004-2006 он							
№	Сумдын нэр	Нас барсан хүн			Нас баралтын ерөнхий коэффициент		
		2004	2005	2006	2004	2005	2006
1	Алдархаан	20	19	18	5.2	5.1	4.9
2	Асгат	6	3	4	5.4	2.7	3.5
3	Баянтэс	16	17	21	5.3	5.6	6.9
4	Баянхайрхан	12	6	22	6.1	3.0	10.9
5	Дөрвөлжин	17	15	9	7.2	6.5	4.0
6	Завханмандал	5	6	6	3.8	4.5	4.5
7	Идэр	22	20	12	8.1	7.4	4.5
8	Их-Уул	37	36	36	5.8	5.7	6.0
9	Нөмрөг	20	10	11	10.7	5.4	5.9
10	Отгон	12	14	13	3.4	4.0	3.7
11	Сантмаргац	21	12	8	9.9	5.7	3.8
12	Сонгино	9	11	12	4.7	5.7	6.2
13	Тосонцэнгэл	50	65	37	5.5	7.2	4.0
14	Түдэвтэй	12	8	11	6.0	4.0	5.5
15	Тэс	18	15	20	5.6	4.6	5.7
16	Тэлмэн	17	18	30	6.0	6.4	10.7
17	Ургамал	8	8	6	4.3	4.4	3.4
18	Цагаанхайрхан	5	10	9	2.7	5.5	5.1
19	Цагаанчулуут	8	6	9	5.3	4.0	6.0
20	Цэцэн-Уул	7	7	15	3.3	3.3	7.0
21	Шилүүстэй	12	14	9	4.9	5.7	3.7
22	Эрдэнэхайрхан	7	7	10	3.8	4.0	5.7
23	Яруу	18	21	10	6.7	8.2	4.0
24	Улиастай	110	101	110	7.1	6.4	6.8
	Завхан аймаг	469	449	448	5.7	5.2	5.5

Эх үүсвэр: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчны судалгаа 2007 он

Завхан аймгийн хувьд нас баралтын түвшин буурсан байдалтай харагдаж байгаа хэдий ч бууралт харьцангуй бага байна. Нас баралтын ерөнхий коэффициент өссөн, буурсан хэлбэлзэлтэй байгаа ба 2006 оны байдлаар аймгийн 1000 хүн тутамд 5.5 нас баралт ногдож байна.

Нас баралтын түвшин хамгийн өндөр сумдад

Баянхайрхан, Тэлмэн (1000 хүн тутамд 11 нас баралт), харин хамгийн бага түвшинтэй сумдад Ургамал, Асгат (1000 хүн тутамд 3 нас баралт) орж байна.

Хүн амын төрөлт, нас баралтын түвшингээс хамаарч хүн амын цэвэр өсөлтийг тооцож болдог. Завхан аймгийн хүн амын сүүлийн 3 жилийн цэвэр өсөлт дараах байдалтай байна.

ЛЫН ХҮН АМЫН СЭТГЭЛТ 2006/10

Хүснэгт 5. Завхан аймгийн хүн амын абсолют цэвэр өсөлт, 2004-2006 он					
№	Сумуудын нэр	Хүн амын цэвэр өсөлт			
		2004	2005	2006	Дундаж
		31	56	43	43
1	Алдархаан	19	14	22	18
2	Асгат	51	69	39	53
3	Баянтэс	35	41	3	26
4	Баянхайрхан	30	33	45	36
5	Дөрвөлжин	25	14	16	18
6	Завханмандал	19	22	43	28
7	Идэр	85	97	118	100
8	Их-Уул	4	20	28	17
9	Нөмрөг	89	63	73	75
10	Отгон	20	31	47	33
11	Сантмаргац	29	17	20	22
12	Сонгино	82	79	140	100
13	Тосонцэнгэл	19	22	11	17
14	Түдэвтэй	51	36	33	47
15	Тэс	35	33	19	29
16	Тэлмэн	22	23	29	25
17	Ургамал	23	27	18	23
18	Цагаанхайрхан	13	19	36	23
19	Цагаанчулуут	28	31	39	33
20	Цэцэн-Уул	40	24	41	35
21	Шилүүстэй	17	10	23	17
22	Эрдэнэхайрхан	18	12	50	27
23	Яруу	129	203	204	179
24	Улиастай	914	996	1160	1023
	Завхан аймаг				

Хүснэгт 5. Завхан аймгийн хүн амын абсолют цэвэр өсөлт, 2007 он

Эх үүсвэр: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчны судалгаа 2007 он

Завхан аймгийн хувьд хүн амын абсолют өсөлт өмнөх онуудаас нэмэгдсэн байна. Гэхдээ аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд дунджаар 1023 хүн нэмэгдсэн нь харагдаж байгаа ба энэ нь харьцангуй бага тоо юм.

4. Завхан аймгийн хүн амын ажил эрхлэлт ба ажилгүйдлийн түвшин

Сумуудын ажил эрхлэлтийн байдлыг салбараар нь авч үзэхэд сумдын ажиллагсдын ихэнх хувийг малчид эзэлж байна. 2005 онд ихэнхи сумын хувьд ажил эрхлэлт өндөр түвшинд байснаа 2006 оноос буурах хандлага илэрч байна. Цөөн хэдэн сумдад газар тариалангийн салбарт нилээд ажилчид ажиллаж байгаа ба үүний жишгээр бусад гэсэн салбарын ажил эрхлэлт өндөр гарч

байна. Тухайлбал: Идэр суманд 204 иргэн, Яруу суманд 198 иргэн газар тариалан эрхэлж байхад Тосонцэнгэл суманд 290 иргэн үйлдвэрлэлийн салбарт, 64 иргэн газар тариалангийн салбарт, Тэс суманд 85 иргэн үйлдвэрлэлийн салбарт ажилладаг гэсэн судалгаатай гарсан байна. Хөдөө орон нутагт ажиллагсдын 70 орчим хувь нь тусгай дунд боловсролтой 20 орчим хувь нь дээд боловсролтой, харин 5 орчим хувь нь бүрэн дунд боловсролтой, 4 орчим хувь нь бага боловсролтой байна.

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил хүн амын идэвхитэй байдлыг харуулдаг үзүүлэлт бол эдийн засгийн идэвхитэй хүн ам болон ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин юм. Сумдын хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувь аймгийн хэмжээнд 72.24, харин Завханмандал сум хамгийн өндөр 84.36 хувь, Тосонцэнгэл суманд 55.42 хувь буюу хамгийн бага үзүүлэлттэй байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувь				
Д/д	Сумуудын нэр	Хөдөлмөрийн насны нийт хүн ам	Эдийн засгийн идэвхитэй хүн ам	Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх эдийн засгийн идэвхитэй хүн ам
1	Алдархаан	2413	1603	66.43
2	Асгат	968	789	81.50
3	Баянхайрхан	1312	1048	79.9
4	Баянтэс	1944	1345	69.19
5	Дөрвөлжин	1456	1112	76.37
6	Завханмандал	876	739	84.36
7	Идэр	1712	1271	74.24
8	Их-Уул	3838	3105	80.90
9	Нөмрөг	1181	855	72.40
10	Отгон	2228	1856	83.30
11	Сонгино	1331	1059	79.56
12	Сантмаргац	1292	1044	80.80
13	Тосонцэнгэл	6750	3741	55.42
14	Түдэвтэй	1313	987	75.17
15	Тэс	2531	1412	55.79
16	Тэлмэн	1788	1339	74.89
17	Цагаанхайрхан	1155	880	76.19
18	Цагаанчулуут	923	758	82.12
19	Цэцэн-Уул	1336	973	72.83
20	Шилүүстэй	1611	1303	80.9
21	Эрдэнэхайрхан	1189	950	79.90
22	Яруу	1673	1371	81.95
23	Ургамал	1081	875	80.94
24	Улиастай	11005	7758	70.5
	Завхан аймаг	52836	38173	72.42

Эх үүсвэр: Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчны судалгаа 2007 он

Ажилгүйдлийн түвшин нь аливаа нэг улс орны нийгэм эдийн засгийн нэг гол үзүүлэлт бөгөөд Завхан аймгийн хэмжээнд энэ үзүүлэлт 4.4 хувьтай байна. Сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээний болон сумуудын ажилгүйдлийн түвшин буурах хандлагатай болж байгаа нь Хөдөлмөр халамжийн газраар дамжуулан бүртгэлтэй ажилгүйчүүд нь ажилд орж

байгаатай холбоотой юм. Цаашид сумдад байгаа бүртгэлгүй ажилгүйчүүдийн тоог нарийн сайн тооцон гаргаж эдийн засгийн ачааллыг нь тооцоолох шаардлагатай байна.

Завхан аймгийн хүн ам зүйн орчны судалгааг судалсны үндсэн дээр дараах эерэг болон сөрөг хандлагууд харагдаж байна.

Эерэг хандлагууд:

- Нийт хүн амд өсвөр, залуу насныхан зонхилох хандлагатай байна. Энэ нь цаашдаа тус аймагт хөдөлмөрийн нөөц байна гэсэн үг юм.
- Сүүлийн жилүүдэд шилжин явагсад багасаж байна.
- Төрөлтийн тоо нэмэгдэх хандлагатай байна.
- Хөдөө амьдрах хүмүүсийн тоо нэмэгдэх хандлагатай байна.
- Ажил эрхлэлт нэмэгдэх хандлагатай байна.
- Бүртгэлтэй ажилгүйчүүд ажилд орох байдал өсөх хандлагатай байна.

Сөрөг хандлагууд :

- Завхан аймгийн хүн амын хэтийн тоо буурах хандлагатай байна.
- Төрөлтийн түвшин хэдий нэмэгдэх хандлага харагдаж буй ч дорвитой өсөхгүй байна.
- Нас баралтын түвшин дорвитой буурахгүй байна.

- Хүн амын хүйсийн хувьд эмэгтэйчүүд илүү хувийг эзэлж байна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллагсадын тоо нэмэгдэхгүй байна.

Ашигласан материал

Монгол улсын төрөөс баримтлах хүн ам зүйн бодлого 1996, УБ

1. Монгол улсын “ Засгийн газрын баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр” 2005, УБ
2. П.Гансүх, Монгол улсын хүн ам зүйн менежмент 2000, УБ
3. Д.Пүрэвдорж, Завхан аймаг 2006 УБ
4. ҮСГ, Монгол улсын статистикийн эмхэтгэл 2000, 2006, УБ
5. “Завхан аймгийн нийгэм эдийн засгийн орчин”- ы судлагааны мэдээлэл 2007, Улиастай